

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/71/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jennisbekh@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/71/НА-СТА-ТШЗ

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
 3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
 4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
 6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ЦЭНГЭЛ СУМЫН ХҮҮХДИЙН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
С.АЙБАРША ТАНАА

2024.02.14 № 84
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд онцлох асуудал гараагүй байна.

Аудитын гол асуудал

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

00402128

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>124831302.00</u>	<u>292045898.92</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	92982279.00	255557718.92
31211	Төрийн сангийн харилцах	92982279.00	255557718.92
35	БАРАА МАТЕРИАЛ	31849023.00	36488180.00
351	Түүхий эд материал	31900.00	31900.00
35130	Эм боох материал	31900.00	31900.00
354	Хангамжийн материал	31817123.00	36456280.00
35410	Бичиг хэргийн материал	270000.00	270000.00
35420	Аж ахуйн материал	21892880.00	28831330.00
35440	Түлш, шатах тослох материал	80000.00	0.00
35460	Хүнсний материал	9574243.00	7354950.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>240334688.07</u>	<u>245338908.75</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	240334688.07	245338908.75
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	233420688.07	238424908.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	249879209.42	249879209.42
39202	Хуримтлагдсан элэгдэл	-52881350.25	-66070437.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25213000.00	41372800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5798966.75	-10611803.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26716763.90	27308763.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17722968.13	-20986545.07
39214	Бусад үндсэн хөрөнгө	15650000.00	26402526.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7635000.12	-8869604.54
393	Биет бус хөрөнгө	6914000.00	6914000.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6914000.00	6914000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>365165990.07</u>	<u>537384807.67</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	432000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	432000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	365165990.07	536952807.67
51	Засгийн газрын хувь оролцоо	365165990.07	536952807.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71262166.00	71262166.00
51101	Өмч: - төрийн	71262166.00	71262166.00
512	Хуримтлагдсан үр дүн	119114463.67	290901281.27
51210	Өмнөх үеийн үр дүн	119114463.67	119114463.67
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	171786817.60
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	174789360.40	174789360.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>365165990.07</u>	<u>537384807.67</u>

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	622,125,600.00	859,025,826.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,701,500.00	23,994,526.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	12,701,500.00	23,994,526.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	560,127,700.00	809,841,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	560,127,700.00	809,841,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,192,900.00	25,190,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,192,900.00	25,190,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	540,177,481.05	687,239,008.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,177,481.05	687,239,008.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	539,963,334.05	687,233,873.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	360,234,485.00	453,363,130.08
210101	Үндсэн цалин	308,893,963.00	347,067,350.89
210102	Нэмэгдэл	44,948,222.00	89,683,345.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-
210104	Урамшуулал	6,392,300.00	16,612,434.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,600,700.00	87,401,400.00
210201	Тэтгэврийн даатгал	41,936,300.00	59,429,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,916,400.00	6,993,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,932,800.00	5,594,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	983,600.00	1,398,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,831,600.00	13,986,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,456,989.00	24,965,065.00
210301	Гэрэл, цахилгаан	1,023,889.00	990,057.00
210302	Түлш, халаалт	18,433,100.00	22,139,008.00

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210303	Цэвэр, бохир ус	-	-
210304	Байрны түрээс	-	1,836,000.00
2105	Нормативт зардал	64,678,597.00	80,829,023.00
210502	Хоол, хүнс	64,678,597.00	80,829,023.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300,000.00	300,000.00
210604	Урсгал засвар	300,000.00	300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,110,000.00	1,095,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,110,000.00	1,095,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,582,563.05	39,280,255.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,453,000.00	13,462,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,828,900.00	3,317,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,300,663.05	22,500,105.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214,147.00	5,135.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	103,500.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	103,500.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	110,647.00	5,135.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,647.00	5,135.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	81,948,118.95	171,786,817.60
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	81,948,118.95	171,786,817.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	609424100.00	835031300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	560127700.00	809841100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	560127700.00	809841100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49192900.00	25190200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49192900.00	25190200.00

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	514742821.00	668946060.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514742821.00	668946060.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514528674.00	668940925.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	360234485.00	453353130.08
210101	Үндсэн цалин	308893963.00	347262189.89
210102	Нэмэгдэл	44948222.00	89478506.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	6392300.00	16612434.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61600700.00	87411400.00
210201	Тэтгэврийн даатгал	41936300.00	59439300.00
210202	Тэтгэмжийн даатгал	4916400.00	6993400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3932800.00	5594500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	983600.00	1398100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9831600.00	13986100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19536989.00	24885065.00
210301	Гэрэл, цахилгаан	1023889.00	990057.00
210302	Түлш, халаалт	18513100.00	22059008.00
210303	Цэвэр, бохир ус		1836000.00
2105	Нормативт зардал	59165500.00	78609730.00
210502	Хоол, хүнс	59165500.00	78609730.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300000.00	300000.00
210604	Урсгал засвар	300000.00	300000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1110000.00	1095000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1110000.00	1095000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12581000.00	23286600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7331000.00	19968800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5250000.00	3317800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214147.00	5135.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	103500.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	103500.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	110647.00	5135.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	110647.00	5135.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	94681279.00	166085239.92
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1699000.00	3509800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1699000.00	3509800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1699000.00	-3509800.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	92982279.00	162575439.92
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		92982279.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	92982279.00	255557718.92

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх	71,262,166.00	174,789,360.40	119,114,463.67		365,165,990.07

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

	үлдэгдэл					
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,262,166.00	174,789,360.40	119,114,463.67	0.00	365,165,990.07
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,262,166.00	174,789,360.40	119,114,463.67	0.00	365,165,990.07
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	71,262,166.00	174,789,360.40	119,114,463.67	0.00	365,165,990.07
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,262,166.00	174,789,360.40	119,114,463.67	0.00	365,165,990.07
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			171,786,817.60		171,786,817.60
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,262,166.00	174,789,360.40	290,901,281.27	0.00	536,952,807.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	928013600.00	672450725.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	928013600.00	672450725.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	928013600.00	672450725.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	696527800.00	453353130.08
210101	Үндсэн цалин	461091200.00	347262189.89
210102	Нэмэгдэл	214392100.00	89478506.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	21044500.00	16612434.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88692300.00	87411400.00
210201	Тэтгэврийн даатгал	60310300.00	59439300.00
210202	Тэтгэмжийн даатгал	7095900.00	6993400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5676500.00	5594500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1418600.00	1398100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14191000.00	13986100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24890200.00	24885065.00
210301	Гэрэл, цахилгаан	2527800.00	990057.00
210302	Түлш, халаалт	20362400.00	22059008.00
210303	Цэвэр, бохир ус	2000000.00	1836000.00
2105	Нормативт зардал	87146900.00	78609730.00

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	87146900.00	78609730.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	300000.00	300000.00
210604	Урсгал засвар	300000.00	300000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1105900.00	1095000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1105900.00	1095000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29350500.00	26796400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26032700.00	23478600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3317800.00	3317800.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	835031300.00	835026165.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	809841100.00	809841100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	809841100.00	809841100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25190200.00	25185065.00
132001	Орон нутгийн төсвөөс	25190200.00	25185065.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		92982279.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		255557718.92
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30.0	30.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	17.00	17.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь “Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих эрүүл таатай орчин бүрдүүлж, бүтээлч эвсэг хамт олон болоход энэхүү зорилго оршино, Хүүхдийн суралга хүмүүжил, хөгжил хүүхэд хамгаалалын асуудалаар эцэг эхтэй хамтран ажиллах гэрээ байгуулж тэдний үүрэг хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх” зорилго дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус цэцэрлэгийн 2023 оны үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газар, Аймгийн Боловсролын газар, аймгийн ЗДТГазраас шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 172.2 сая төгрөгөөр буюу 47 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	92982.3	255557.7	162575.4
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	31849.0	36488.2	4639.2
Үндсэн хөрөнгө	240334.7	245338.9	-5004.2
Нийт хөрөнгө	365166.0	537384.8	172218.8
Өр төлбөр	0	432.0	432.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	365166.0	536952.8	171786.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	365166.0	537384.8	172218.8

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцэст 255.6 сая төгрөг болж оны эхнээс 162.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүний 244.5 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн, 2.6 сая төгрөг нь бараа үйлчилгээний бусад зардал, 8.5 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардлын төсвөөс үлдсэн мөнгө байна.

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Бараа материал дансны үлдэгдэл оны эцэст 36.5 сая төгрөг болж 4.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хүнсний материал 7.4 сая төгрөг, аж ахуйн материал 28.8 сая төгрөг болж нэмэгдснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 245.3 сая төгрөг болж 5.0 сая төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө 27.5 сая төгрөгөөр нэмэгдэж, 22.5 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Оны эцэст 0.4 сая төгрөгөөр өглөг нэмэгдсэн байна. Энэ нь аудитын төлбөрийн нэхэмжлэхтэй холбоотой гарсан өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 365.2 сая төгрөг болж 171.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 171.8 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 562.6 сая, орон нутгийн төсвөөс 25.2 сая, нийт зарлагыг 587.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 605.8 сая төгрөгөөр хянаж, 43.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсвийн тодотголоор 204.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 809.8 сая төгрөг болгон тодотгож баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 25.2 сая төгрөгөөр баталж, тодотголоор өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 809.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 25.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 835.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 809.8 сая, орон нутгийн төсвөөс 25.2 сая нийтдээ 835.0 сая төгрөгийн санхүүжилт авч 93.0 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 672.4 сая төгрөг буюу 72.5 хувьтай буюу дансанд 255.6 сая төгрөгийн үлдэгдэл гарсан байна. Төсвийн харилцах дансанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй гарсан нь төсвийн төлөвлөлт, хуваарилалттай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/				
д/д		Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605	Эрүүл мэндийг дэмжих	1658.9	1658.9	0	100%
2	81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	75563.9	70830.2	4733.7	93.7%
3	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	8059.1	5520.0	2539.1	68.5%
4	81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1658.9	1658.9	0	100%
5	81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	47385.1	33062.4	14322.7	69.8%
6	81834	Боловсролын стандарт, сургалтын	520484.5	349632.0	170852.5	67.1%
7	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	248013.0	184903.2	63109.8	74.6%

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

8	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	25190.2	25190.2	0	100%
Нийт дүн			928013.6	672455.8	255557.8	72.5%

Цэцэрлэгийн төсвийн гүйцэтгэл нь төлөвлөснөөс 255.5 сая төгрөгөөр бага гүйцэтгэлтэй гарчээ. Үүнд: цалингийн зардал 243.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1.3 сая, бараа үйлчилгээний бусад зардал 2.5 сая, хүүхдийн хоолны зардал 8.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс бага гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 95.3 сая төгрөгийн бараа материал, 3.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Буянт сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 540.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 10.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс санхүүгийн тайлангийн аудитын программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 49.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрч зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас ажилтнуудад 16.0 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Мэдээлэл технологийн үйлчилгээ 1.1 сая, цалингийн зардал 0.7 сая, түлш халаалтын зардал 19.8 сая, гэрэл цахилгааны зардал 1.0 сая, цэвэр бохир усны зардал 1.9 сая, бараа үйлчилгээний бусад зардал 9.1 сая, нийт 33.6 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулан тооцоо хийгээгүй, шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

3.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.2, 20.2, 20.2.5 дахь заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх аргачлал, зааврыг мөрдөж аливаа гүйлгээг тооцооны данс дамжуулан бүртгэж тайлагнах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон	1	16,000.0					1	16,000.0				
Зарим зардлыг тооцооны дансаар дамжуулан тооцоо хийгээгүй шууд зардлаар бүртгэсэн	1	33,588.8					1	33,588.8				
Дүн	2	49,588.8					2	49,588.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								

Цэнгэл сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

Нийт дүн									
----------	--	--	--	--	--	--	--	--	--